

МОНГОЛ ШҮЛГИЙН СҮҮЛ ХОЛБОЦЫН ЗАРИМ ОНЦЛОГ®

Г. Галбаяр*

Хүн төрөлхтөн өмнөх үеийнхээ бүтээсэн ололттой сайн зүйлийг цаг ямагт судлан шинжилж, учир зүйг нь тодруулан тухайн цаг үеийнхээ хөгжил дэвшилд нэвтрүүлж, алдаа оноогоо шүүж, ахин дэвших зам мөрөө тодруулдаг. Монголчууд түүхэндээ оюуны болоод эдийн арвин баялаг соёлыг бүтээсэн нь хойч үеийн бидэнд ямар нэг хэмжээгээр өвлөгдөн үлджээ. Тэртээ олон зууны чинадаас монгол хүний мандаж буурч явсан түүхэн ул мөрийг тодруулахад тэдний үлдээсэн соёлын өв чухал баримт болно. Өвөг дээдсийн бүтээсэн соёлын олон зүйл цаг хугацааны шүүлтүүрээр шүүгдэж, он цаг өнгөрөх тусам нэг талаасаа өнгө гийж, утга учир нь төгөлдөржих ч нөгөө талаасаа улам бүдгэрч, ухаж ойлгохуйяа бэрх ээдрээт зүйл болж байна. Туулж ирсэн түүхэн зуунуудын сургамжид дулдуйдаж, санаанаасаа санаа, бодлоосоо бодол ургуулж давхар давхар нарийн зүй тогтолын сүлжээгээр бүтээсэн эрхэм чухал, чинад алсын өвөрмөц зүйлсийн мөн чанар л улам бүдгэрч, ээдрээтэй санагдах ч үнэн хэрэгтээ нүүдэлчин монголчуудын оюун сэтгэлгээний утга учир, уран зангилаа, жинхэнэ охь дээж болон огшиж байдаг бөлгөө. Монголчуудын бүтээсэн тийм эрхэм чухал зүйлийн нэг бол хөг эгшиг, хөгжим аялгуу, утга санаа ундарсан уран дүрслэлт шүлэг найраг юм.

Монгол хүний аж амьдрал, сэтгэлгээний олон чухал зүйлийг уран сайхны үүднээс өвөрмөц олон аргын цогцлолоор бүтээгдэж, он цагийн урсгалд үе үеийнхний үзэл санаа, сэтгэлгээний охь дээжсээр сэлбэгдэн баяжиж ирсэний хувьд монгол шүлэг баялаг агуулга, өвөрмөц хэлбэр бүтэц, зүй тогтолтой урлаг. Монгол шүлэгт монгол үндэстний сэтгэлгээний цөм хэв загвар, язгуур үзэл санаа цогцоороо хадгалагдан үлдсэн байна. Тиймээс монгол шүлгийн мөн чанараас монгол хүний сэтгэлгээний нарийн зүй тогтол, түүхэн ул мөрийг тодруулан үзэх бүрэн боломжтой юм.

Монголчуудын аж амьдрал, түүхэн замналыг улируулан тэдний бүтээсэн оюуны соёлын өв санг цогцоор нь бие биенийх нь харилцан шүтэлцээнд орчин үеийн олон шинжлэх ухааны бэлчир зангилаан дээр судлах нь зайлшгүй чухал болох нь тодорхой болж байна. Нэн даруй далайцтай өргөн дэлгэр хүрээнд судлууштай олон асуудал байгаагийн нэг нь бидний өгүүлэн буй монгол шүлгийн асуудал юм. Монгол шүлгийн судлал гэдэг түүхэн зүй тогтол, бүтэц тогтолцоо, дотоод мөн чанар гээд олон талтай өргөн дэлгэр асуудал тул энэ удаа бид зөвхөн сүүл холбоцын зарим нэг онцлогийг тодруулан үзэж байгаа болно.

® This work was supported by Hankuk University of Foreign Studies Research Fund of 2011

* Professor of Hankuk University of Foreign Studies, Korea

Улс үндэстэн бүрийн аж амьдрал, сэтгэлгээ, түүхэн замналын ул мөрийг хадгалж байдгийн хувьд үндэстэн бүрийн шүлэг найраг өөрийн гэсэн өвөрмөц онцлог, нарийн зүй тогтолтой байдаг. Шүлэг буюу яруу найргийг бүтээж байдаг дотоод мөн чанар дахь амин чухал асуудлуудын нэг нь айзам хэмнэл, аялгуу холбоц юм. Яруу найраг туурвигч этгээдийнхээ сэтгэлгээний цөм хэв загвар болсон төрөлх хэл аялгууны эвсэн найрсан хамгийн товч хувилбараар гүнзгий утга санааг тээж илэрдэгийн хувьд яруу сонсголонтой, хувьсан хөгжих дотоод удисыг өөртөө шингээсэн байдаг.

Шүлгийн ерөнхий бүтэц тогтолцоог тодотгох нэг чухал зүйл нь олон янзын холбоц юм. Холбоцыг яруу найргийн онолд *“Шүлгийн байгуулалтыг тодруулагч нэг зүйл бол толгой холбоц зэрэг алив холболт нь болно. Энэ бол уран зохиолын хэлэнд авиаг ашигласан явдал гэж бас болох мэт. Учир нь алив нэг холбоц ижил буюу төсөөт авиануудыг журамтайгаар давтан хэрэглэх үндэс дээр бүтээгдэнэ”*¹, *“шүлгийн хэлэнд тухайн үндэстний хэлний авиаг зөв найруулан ашиглаж, тодорхой эрэмбэ тогтолцоо үүсгэсэн явдал”*², *“Шүлгийн хоёроос дээш шатыг авианы дуудлага ижил төсөрхүү байгаагаар нь ижилсүүлэн холбох аргыг холбоц гэж хэлдэг”*³ гэсэн утгатайгаар ойлгодог. Энэ мэт шүлгийн холбоцын тухай онолын бүтээлүүдээс үзвэл шүлгийн аливаа холбоц нэг шадыг нөгөө шадтай уялдуулан холбож, шүлгийн ерөнхий бүтэц тогтолцоог үүсгэх гол үүрэгтэйгээс гадна уншиж, сонсоход яруу уянгалаг шинжтэй байх үүргийг давхар гүйцэтгэдэг байна. *“Холбоц нь зөвхөн авианы чимэг дуудлага төдий биш утгын, хэмнэлийн агуулгыг өөртөө шингээсэн байна.”*⁴ Үндэстэн бүрийн хэл, сэтгэлгээний онцлогоос хамаарч шүлгийнх нь холбоцын үндэс янз бүрийн онцлогтой байдаг. Холбоц нэг болон түүнээс дээш хэдэн ч авианаас бүтэж болно. Холбосон шадуудын бүх холбоц ижил авиагаар эхлэж төгсөж байвал бүрэн холбоц, ижил бус авиагаар холбогдож байвал бүрэн бус холбоц, эгшиг үсгээр төгсөж байгаа бол нээлттэй холбоц, гийгүүлэгчээр төгсөж байгаа бол хаалттай холбоц, байрлалаар нь холбоцуудыг зэрэгцсэн, хашсан, салаавчилсан гэх зэргээр ялган салгаж нэрлэдэг.

Шүлгийн холбоцыг ерөнхий бүтцийн хувьд толгой холбоц, дунд холбоц, сүүл холбоц хэмээн томъёолдог. Үндэстэн бүрийн сэтгэлгээний онцлог, ертөнцийг үзэх үзэл баримтлал, хэл, соёлын гээд олон зүйлээс нь шалтгаалан шүлэг найрагт нь янз бүрийн холбоцууд байдаг. Жишээ нь, монгол хүний аливаа зүйлийн эхлэлийг чухалчилж үздэг үзэл сэтгэлгээтэй холбоотойгоор монгол шүлэгт толгой холбох ёс тэргүүлэх үүрэгтэй байдаг ч дунд болоод сүүл холбоц дагалдах шинжтэй. Монгол шүлгийн толгой холбоцын зарим онцлогийг *“Д. Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлгийн толгой холбоцыг харьцуулах нь”* (МУИС-ийн МХСС-ийн МОНГОЛ СУДЛАЛ эрдэм шинжилгээний бичгийн ХХХII боть. Уб., 2010. 122-130 дугаар тал) гэсэн өгүүлэлээс тодруулан харах боломжтой. Өрнийнхөн аливаа зүйлийн төгсгөлийг хичээж онцгой сайнаар дуусгахыг чухалчилдаг сэтгэлгээнийхээ үүднээс шүлгийнхээ сүүл холбоцонд онцгой анхаардаг байна. Шүлгийн сүүл холбоцыг илэрхийлэх нэр томъёог франц хэлний *“rime masculine”* (эр холбоц), *“rime feminine”* (эм холбоц) гэсэн үгсээс үүссэн гэж үздэг. Францчууд эр холбоц гэж үл өгүүлэх *“e”*-ээр эс төгссөн холбоцыг хэлдэг бол эм холбоц гэж үл өгүүлэх *“e”*-гээр төгссөн холбоцыг хэлдэг байна. Өөрөөр хэлбэл франц хэлэнд зөв бичих дүрмийн үүднээс үгийн төгсгөлд *“e”* бичээд дуудахдаа эс

¹ Гаадамба Ш. *Уран зохиолын онолын үндэс*. Уб., 1989. 154 дүгээр тал

² Жирмунский В. *Теория стиха*. Л., 1975. стр-146

³ Дулам С., Хасбаатар Ц. *Уран зохиолын онолын үүд*. Уб., 1980. 183 дугаар тал

⁴ Байгалсайхан С. *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Уб., 1995. 108 дугаар тал.

уншдаг. Үүнийг эм холбоц гэж тооцоод энэхүү үл уншигдах “е”-гийн өмнөх үеийн холбоцыг эр холбоц гэж нэрлэдэг байна. Европын бусад орнууд энэхүү холбоцуудыг өөр өөрийн хэлэнд уялдуулан өөр өөрийнхөөрөө нэрлэхээс гадна тодорхой өөрчлөлтүүдийг хийсэн байна. Тухайлбал, оросууд эр холбоцыг “*мужская рифма*”, эм холбоцыг “*женская рифма*” хэмээн нэрлээд үгийн төгсгөлд өргөлт оногдох эгшигтэй үеийг эр холбоц, сүүлээсээ өргөлт оногдох хоёр дахь үеийг эм холбоц гэж нэрлэдэг. Тэгвэл сүүлээсээ өргөлттэй гурав дахь үеийг франц хэлээр “*rime dactylique*”, англи хэлээр “*dactylic rime*”, орос хэлээр “*дактилическая рифма*” гэх зэргээр нэрлэж холбоц үүсгэдэг. Үүнийг монголоор “*хуруун холбоц*” гэж орчуулж заншжээ.

Монгол шүлэгт толгой холбох ёс тэргүүлэх үүрэгтэй ч түүнээс урган гарч, түүний оршин байх үндэс суурьтай холбоотой дунд холбоц, сүүл холбоцууд дагалдах шинжтэй байдаг. Монгол шүлэгт толгой холбоц тэргүүлэх үүрэгтэй гэсэн судлаачдын судалгаа шинжилгээний үнэлэлт дүгнэлт, бодит байдал зэргийг бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрөхөөс аргагүй ч тэрхүү толгой холбоцын нэг гол тулгуур болж, дагалдах шинжтэй байгаа дунд хийгээд сүүл холбоцын асуудлыг нарийвчлан судлах нь чухал. Монгол шүлгийн дунд холбоцын тухай “*Монгол шүлгийн дунд холбоцын зарим онцлог*” (“*Зүүн хойт Азийн нүүдэлчдийн соёлын загвар ба харилцаа*” сэдэвт хурлын эмхэтгэл. Сөүл, 2011. 58-75 дугаар хуудас) өгүүлэлээс тодруулан харж болно. Энэ удаа бид монгол шүлгийн сүүл холбоцын зарим асуудалд анхаарлаа хандуулж байна.

Монгол шүлгийн бүтэц дэх толгой, дунд, сүүл холбоц нь монголчуудын дээд, дунд, доод гэсэн босоо загварын сэтгэлгээтэй холбоотой юм. Иймээс үндэстний сэтгэлгээ нэгэн цогцоороо байж үнэ цэнтэй, утга учиртай байдгийн адил монгол шүлгийн холбоцыг бүх талаас нь судалж байж мөн чанар нь улам тодрох болно. Монгол шүлгийн сүүл холбоц утга, үүргийн хувьд толгой, дунд холбоцтой ижил төстэй. Өөрөөр хэлбэл гүн гүнзгий утга агуулга бүхий яруу сонсголонт шүлгийн бүтцийг эмх цэгцтэй эрэмбэ дараалалтай болгодог гэсэн үг. Энэ нь нүүдэлчин монголчуудын сэтгэлгээ түүний илэрхийлэл болсон шүлэг найрагт санамсаргүй хэлбэрээр сонгогдсон хэрэгцээгүй нэг ч зүйл байдаггүй. Бүгд дотоод мөн чанартаа нарийн зүй тогтолтой, нэгээс нөгөө нь урган гарч, дараагийн өөр нэгний уг үүдгэл болдог өвөрмөц урлал хийц болох нь дамжиггүйг харуулна.

Хоёр болоод түүнээс дээш шад шүлэгт толгой, дунд холбохоос гадна шадын төгсгөлд ижил буюу төстэй авиагаар холбосныг монгол шүлэг судлалд сүүл холбоц хэмээн нэрлэдэг.

Шүлэг бол хүний сэтгэлийг хөглөх, ухааныг ундраах, итгэлийг бадраах удистай байдаг. Тийм ч учраас үгийн удисыг амилуулах нь шүлэгчийн үүрэг юм. Үг уддисаар амилах нь уран сайхны олон аргын төгс хослол. Монгол шүлгийн уран сайханд шүлгийн сүүл холбоц чухал үүрэгтэй.

Бидний бодлоор уран зохиол туурвигддаг онолын сэтгэлгээний үүднээс авч үзсэн ч, бодит амьдралын туршлагаас мөшгөн хөөж судалсан ч монгол уран зохиолын эх ундрага, хөрс суур нь ардын аман зохиол. Тиймд монгол шүлгийн ерөнхий онцлог мөн чанар, бүтэц тогтолцооны асуудлыг энэ хөрс суурин дээрээс нь орчин үеийн утга зохиол судлалын болоод өөр бусад тусыг хүргэж болох шинжлэх ухаануудын уулзвар дээр тэдний шинэ хийгээд шалгарсан сайн арга барилаар далайцтай судлах нь зайлшгүй чухал зүйл юм. Энэ удаад монгол ардын аман зохиолын арвин баялаг өв сангаас цөөн жишээ татан өгүүлье.

Монгол шүлгийн бүтэц тогтолцоо, утга агуулгыг арга билгийн үүднээс хадгалдаг үндсэн нэгж нь хос уянга. Хос уянгын сонгодог жишээ бол зүйр, цэцэн үг. Зүйр, цэцэн үг хоорондоо нарийн ялгаатай нь ойлгомжтой ч хослосон утгаараа аливаа зүйлийн нэгийг нөгөөтэй нь зүйрлэж дундаас нь мөн чанарыг нь тодруулан цэцэн илэрхийлэхийн нэр. Жишээ нь:

Давс хийвэл уустал

Ажил хийвэл дуустал

* * *

Далай усаар ханадаггүй

Мэргэд номоор ханадаггүй

* * *

Дахан дор эр

Даахин дор хүлэг

* * *

Ерөөлийн үзүүрт тос

*Хараалын үзүүрт цус*⁵ ... гэсэн зүйр, цэцэн үгүүдийг ажиглахад байгаль ертөнц, адгуус амьтны ямар нэг шинж чанарыг эхний мөрөнд илэрхийлээд түүнтэйгээ уялдуулан дараагийн мөрөнд хүний ямар нэг шинжийг ургуулан товойлгож дүрслэн мөн чанарыг нь тодруулан хос уянга үүсгэсэн байна. Хос уянгын төгсгөлийг ижил үг, ижил нөхцөл, дагавар, ижил дуудлагатай үг, утга ойролцоо үг, түүгээр ч үл барам эсрэг утгатай үг зэргээр хослуулан уялдуулж, харшуулан нарийн чанд холбосон байна. Энэ нь монгол зүйр, цэцэн үгийн туурвил зүйн арга, онол дотоод мөн чанартаа толгой, дунд, сүүл холбохыг эрхэмлэдэг зарчимтайг харуулж буй хэрэг. Энэ зүй тогтол нь утгаа бол монгол сэтгэлгээ – монгол хэлний авиа утга илэрхийлж, нэгээс нөгөө нь ургаж, нөгөө нь нэгийнхээ үүтгэл болж оршдог мөн чанарт үндэслэгдэж байдаг бололтой.

Зүйр, цэцэн үгийн холбоцыг судлаад судлаач Л. Түдэв “зүйр үг зөвхөн толгой холбоод зогсоогүй сүүл холбосон нь монгол шүлгийн ёсны төгөлдөр хайрцаг болсон гэлтэй. Монгол шүлэг зөвхөн толгой холбодог мэтээр өрнөдийн: мэргэд ухаарч сүүл холбох нь зөвхөн өрнөдийн шинж мэтээр ярьсаар бичсээр уджээ. Гэтэл монгол шүлэг толгой, сүүл хоёуланг нь холбох боломжтойг аль эрт дивангарын цагт харуулжээ”⁶ хэмээн өгүүлсэн байна.

Монгол шүлгийн сүүл холбоцын сонгодог жишээ бол ертөнцийн гурав юм. Жишээ нь:

Өсөхөд шүд цагаан

Өтлөхөд үс цагаан

Үхэхэд яс цагаан (Ертөнцийн гурван цагаан)

* * *

Номгүй бандийн цээж харанхуй

Хоньгүй айлын хот харанхуй

Хойшоо харсан нүх харанхуй (Ертөнцийн гурван харанхуй)

* * *

Газар үндсээр баян

Тэнгэр одоор баян

⁵ Гаадамба Ш., Цэрэнсодном Д. *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*. Уб., 1978. 14 дүгээр тал

⁶ Түдэв Л. *Шүлэглэсэн туульс*. Бүтээлийн чуулган. VI боть. Уб., 2002. 332 дугаар тал

Далай усаар баян (Ертөнцийн гурван баян)⁷ ... гэх мэт. Ертөнцийг өнгөн босоо загварт нь дээд, дунд, доод, гүн босоо загварт нь урд, энэ, хойт хэмээн ухаарч тэр бүхнийгээ өнгөрсөн, одоо, ирээдүйн орчилд холбон авч үзэж сэтгэдэг үүднээс гурван хэмжээсийн чанд илрэх утга нь хоорондын холбоосонд буюу төгсгөлдөө байгаа гэж үзээд төгсгөлийг хамгийн чанд холбоосоор нарийн холбосон байдаг байна. Энэ нь монгол шүлэгт хамгийн гүн холбоц бол бие даасан үгэн улмаар холбоо, хоршоо үг болохыг харуулж байна. Зөв байрлалаа олж утга илэрхийлэх үг, холбоо, хоршоо үгийн хэлхээ холбоо, бүтэц зүй тогтол монгол шүлгийн үндэс суурь болдог.

Тэгвэл оньсогоос жишээ татан үзье.

Цэнхэр цэнхэр пансан хөшиг

Цэвэр тунгалаг сэрүүн хөшиг

Хангай дэлхийг чимдэг хөшиг

Халуун наранд сөхөгддөг хөшиг (Манан)

* * *

Хөлгүй байж явдаг

Нүдгүй байж уйлдаг (Үүл бороо)

* * *

Алтан тэмээ ангас гэнэ

Аргамжийн үзүүр гялс гэнэ (Цахилгаан гялбах)⁸ ... зэрэг оньсогод аливаа нэг зүйлийг бусдын оюун санааны задаргаагаар таалгах зорилготой тул тухайн зүйлийн гол шинжийг онцгой чухалчилан илэрхийлэхдээ шадын төгсгөлд нь төвлөрүүлэн зангидаж шүлэглэдэг зүй тогтолтой уялдаатайгаар мөрүүдийн төгсгөлийг чанд холбосон байна. Монгол шүлэг айзам хэмнэл, түүнийг зохицуулсан аялгуу холбоцуудын үр дүнд төгс утгыг илэрхийлэн гаргадгийн хувьд олон талын онцлог нь оньсогод хадгалагдаж байдаг. Монгол шүлгийн өвөрмөц шинжийг төгөлдөр хэлбэрээр хадгалж байдаг оньсогод холбоцууд чухал үүрэгтэй ч сүүл холбоц онцгой үүрэг байгаа нь монгол шүлэгт сүүл холбоц чухал үүрэг зорилготой бие даасан тогтолцоотой үзэгдэл болохыг батална.

Монгол аман зохиолын олон талын онцлогийг хадгалах өөр нэг зүйл бол ардын дуу юм. Байгалийн янз бүрийн дуу авиаг дуурайн байж хүн хэлтэй болсон нь ойлгомжтой. Хэлний илэрхийлэл үг учир үгээ сэтгэлгээнийхээ бүтэц тогтолцооны дагуу хувирган өөрчилж холбоо хоршоо, улмаар шүлэг зохиол хэлдэг болсон биз. Тийм ч учраас яруу найраг дуурайн дүрслэх үйлдлээс үүссэн хэмээн эртний Грекийн урлагийн онолч Аристотель “*Туурвил зүй*” хэмээх бүтээлдээ батлан өгүүлснийг үе үеийн олон онолч хүлээн зөвшөөрсөөр иржээ.

Дуу авиа, үг хэлний өөрчлөлтийг сэтгэлийн баяр гунигийн үүднээс өөрчлөн уянгалуулан илэрхийлж дууг үүсгэсэн гэж хэлж болно. “*Дуу авиагаа өндөр намаар нь найруулан журамласаар дуулах дуутай болсон хэрэг. Дуу, шүлэг хоёр тийнхүү ихэр төрсөн ах дүүс. Тэгэхээр дууны яруу найраг хэл яриа шиг өндөр настай ажгуу. Үгнээсээ жаахан дүү ч байж мэднэ. Дууны шүлэг бол яруу найргийн ах нь юм. Ахаар нь дүүгийн болоод дараа дараачийн үеийнхний төрхийг зүслэж болно*”⁹ хэмээн судлаачид монгол дууны яруу найраг монгол шүлгийн ерөнхий бүтэц тогтолцоог бүрэн төлөөлнө гэж үзсэн нь санамсаргүй зүйл биш юм. Монгол дууны яруу найрагт сүүл холбоц хэрхэн орсон тухай хоёр жишээ авч үзье.

⁷ Гаадамба Ш., Цэрэнсодном Д. *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*. Уб., 1978. 21 дүгээр тал

⁸ Гаадамба Ш., Цэрэнсодном Д. *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*. Уб., 1978. 26 дугаар тал

⁹ Түдэв Л. *Шүлэглэсэн туульс*. Бүтээлийн чуулган. VI боть. Уб., 2002. 348-349 дүгээр тал

Арван тавны сар нь ай хөө

Агаар тэнгэртээ дэнлүү дээ ай хө

Арван тавтай Шоожоо нь ай хөө

Аав ээждээ дэнлүү дээ ай хө (Арван тавны сар)¹⁰ ... гэсэн шүлгийн эхний хос мөр бол уг шүлгийн цөм хэв шинжийг хадгалсан хос уянга. Байгаль дэлхийн мөн чанарыг илэрхийлсэн уг хос уянга толгой холбогдсоны зэрэгцээ сүүлийг гүн холбож мөр хоорондын уялдааг чандлан нэгтгэж утгыг хэн хүнд ойлгомжтой энгийн товойлгон дүрсэлсэн байна. Дараагийн хос мөрөндөө өмнөх хос уянгын ерөнхий загвар буюу айзам хэмнэл, холбоцуудын хэлбэрийг уламжлан аваад хүний амьдралын мөн чанарыг илэрхийлэн үзүүлжээ. Ингэхдээ тухайн хос уянгын сүүлийг чанд холбосны зэрэгцээ уг шүлгийн нэгдүгээр мөрийг гуравдугаар мөртэй, хоёрдугаар мөрийг дөрөвдүгээр мөртэй сөөлжүүлэн толгой, сүүлийг давхар холбон утгыг урлан айзамыг тааруулсан байна. Монгол шүлэгт холбоцуудыг давхар давхараар олон янзаар холбож шүлгийн айзам хэмнэлийг өөрчлөн хувиргаж, утгыг гүнзгийрүүлэн урладаг болохыг энд тодорхой харуулжээ. “*Арван тавны сар*” хэмээх гүн ухааны уянгад шүлгийн сүүлийг аялга үгээр холбосон нь монгол шүлэг аялга үгийн уртатгал, богиносол тэдний хослолоор шүлгийн мөр хоорондын айзам хэмнэлийг тааруулан холбоц үүсгэж болдог онцлогийг харуулж байна.

Эх үрийн элбэрэл хайрын утгыг илэрхийлсэн “*Бүүвэйн дуу*”-нд:

Харалдай тайжийн хүүлээ бүүлэй

Хар лусын хааны ачлай бүүвэй

Зэндэгээ мэргэний зээлэй бүүлэй

Зэгсэн маагийн хүүлэй бүүвэй ... гэх мэтээр өгүүлсэн байна. “*Бүүвэйн дуу*” нэн эрт цагаас үүсэлтэй. Эх хүн үрээ тайвшруулан муу муухай зүйлээс үгийн хүчээр харамлан хамгаалсан шүлэглэл. Энэ шүлэглэлийн хамгийн чухал зүйл нь үгийг амилуулан эвсүүлж аялсан аялгуу юм. Тухайлбал дээрх “*Бүүвэйн дуу*”-нд энэ хүүхэд чинь тайжийн удамтай, мэргэн харваач баатар эрийн үр сад шүү. Энэ хүүхэд рүү ямар ч муу муухай зүйл ойртож болохгүй гэдгийг үгийн хүчээр амилуулан өгүүлсэн байна. Ингэж үгийг амилуулахад мөр бүрийн холбоц тэр дундаа “*бүүвэй*” (“*бүү ай*” гэсэн утгатай үг) гэсэн амин гол үгээр нь холбосон сүүл холбоц чухал болохыг харуулж байна. Бүүвэй бол муу муухай бүхнийг цаашлуулдаг увдистай аялгуу. Бүүвэй аялахдаа хоёр тийш нэгэн хэмнэлээр жигдхэн хөдөлгөөнтэй хийдэг. Энэ нэгэн хэмнэлийн жигд хөдөлгөөн шүлгийн холбоцуудын зүй тогтолтой шууд холбоотой зүйл. Тиймд шүлгийн сүүл холбоц жигд хэмнэлд үндэслэгдсэн байдаг нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл монгол шүлэг сүүл холбоцтой байгаа нь мөр хоорондоо жигд хэмнэлтэй байгааг, цаашлаад холбоцтой мөрүүд тэнцүү үе, үгээс бүтдэг нь харагдана. Тиймд монгол шүлгийн нэг гол шинж бол шүлгийн шадууд тэнцүү үе, үгтэй байх, улмаар нарийн чанд холбоцтой байх явдал ажээ.

Монгол соёл сэтгэлгээ, шүлэг найргийн олон талын онцлогийг хадгалах өөр нэг гол төрөл бол бөө мөргөлийн яруу найраг юм.

Жишээ нь, бөөгийн яруу найргаас жишээ татаж үзвэл:

Sagán dere salim garahan

Sagáñ xermeñ zalá belé,

Xara dére xalim garahan

¹⁰ Гаадамба Ш., Цэрэнсодном Д. *Монгол ардын аман зохиолын дээж бичиг*. Уб., 1978. 48 дугаар тал

Xarža xerme zalá belé.
Xariñ Xurdud udxamni
Xurdud xýni udxa belé,
Hyxe nojiñ teñgeri belé,
Hyñ sagáñ búdal belé,
Taega gazar búdal belé,
Tal gazar nerjér belé,
Tolgoeñ šinéñ búdal belé,
Topšín šinéñ mender belé,
Šuhuñ jexe xura belé,
Šulúñ jexe myndyr belé,
Gal jexe saxilgáñ belé,

*Gazar jexe doholgón belé!*¹¹ ... гэх мэтээр “*garahan-belé*” гэсэн үгсийг салаавчлан, мөн “*belé*” гэсэн үгсийг зэрэгцүүлэн тогтвортой сүүлийг чанд холбосон байна. Энэ нь аливаа зүйлийн нэгийг нөгөөтэй харьцуулан жишиж мөн чанарыг нь өгүүлдэг онцлогоос болж шүлгийн төгсгөлийг салаавчлан холбодог, аль эсвэл мөн чанарыг нь тоочин дуудах дуудлагаас үүдэж хэлж байгаа шүлгийнхээ сүүлийг зэрэгцүүлэн холбодог онцлог ажиглагдаж байна. Энэ нь ерөөс эртний монголчуудын сэтгэлгээнд нэгийг нөгөөтэй харьцуулан жишиж мөн чанарыг нь ухаардаг ухаарал, эсвэл дэс дараалсан тоочин бүртгэх явдал байсныг харуулж байна. Энэ мэтээр Б. Ринчен “*Les matériaux pour l'étude du chamanisme mongol*” (Wiesbaden., 1961. p.1-143), Б. Содном “Харын зүгийн бөөгийн дуудлаганууд” (Зохиол судлал. Уб., 2008-2009. 138-171 дүгээр тал), Ш. Гаадамба, Д. Цэрэнсодном “Монгол ардын аман зохиолын дээж бичиг” (Уб., 1978. 105-115 дугаар тал) бүтээлүүдийн эхүүдээс харахад шүлгийн сүүлийг нэн тогтвортой холбосон нь харагдаж байна.

Энэ мэтээр монгол аман зохиолын дом шившлэг, ерөөл, магтаал гээд бүх төрөл зүйлээс шүлгийн сүүлийг тогтвортой холбосон энэ мэт жишээ баримтыг тодорхой харж болно. Дээрх жишээ баримтаас үзвэл монгол шүлгийн сүүл холбоц хэлний ижил ба төсөөтэй авиа, үе, үг, хоршоо, холбоогоор шадын төгсгөлийг ижилсүүлэн холбож, шүлгийн уран сайхны үнэ цэнийг нэмдэг зорилготой аж.

Аман зохиолын өв уламжлалыг баяжуулан хөгжиж ирсэн бичгийн яруу найргаас тодорхой жишээ татаж сүүл холбоцын зарим онцлогийг авч үзье.

“Монголын нууц товчоо”-ны 118 дугаар зүйлд:

Temüjin anda:

aula siqan bauya
aduučin bidan-u alačuy-a kürtügey
yol-dur siqan bauya
*qoni(n)čid quriyačid bidan-u qoola-ya kürtügey*¹²

... хэмээн монгол шүлгийн үндсэн нэгж хос уянгыг өрөн шүлэглэсэн бүтээлд хос уянгын эхний мөрүүд болох нэг гуравдугаар мөрийг, хоёр дөрөвдүгээр мөрийг сөөлжүүлэн сүүлийг чанд холбосон байна. Гэтэл шүлгийн толгойг тус тусад нь хос уянгаар холбосон байна. Энэ нь монгол шүлэгт толгой холбосон бол сүүлийг дагуулан холбох албагүйг, өөрөөр хэлбэл сүүл холбоц толгой холбоцоос хараат бус бие даасан хэлбэрт байдгийг харуулж байна.

¹¹ Rintchen. *Les matériaux pour l'étude du chamanisme mongol*. II Textes chamanistes bouriates. Wiesbaden., 1961. p-30

¹² Монголын нууц товчоо. Галиглаж хэвлүүлсэн Т. Дашцэдэн. Уб., 1985. 54 дүгээр тал

Чингис хааныг тэнгэрт халихад Сөнидийн Гилүгэдэй баатар харуусан халаглаж, гашуудлын шүлэг хэлсэн байдаг. Тэр шүлэг нь:

qaliqu qarča-yai-yin jigür bolun odbai ċi

ejen minu

qangginaqu tergen-ü tegesi [=tegeges] bolbai ċi

ejen minu

duyuniq [=duyuliqu] qarča-yai-yin jigür bolun odbai ċi

ejen minu

toyuriqu tergen-ü tegesi [=tegeges] bolbai ċi

ejen minu

jirgikü sibayun-u jigür bolun odbai ċi

ejen minu

jirkiraqu tergen-ü tegesi [=tegeges] bolbuu ċi

*ejen minu*¹³ энэ болно. Энэ шүлэг орчлон ертөнцийн цуглаж барагдаж, ирж буцаж, төрж үхэхийн жам зүйн дагуу хураан эзэлж байгуулсан их улс, ханилж төрүүлсэн хатан хөвгүүд, урин дуудаж шадарласан эрхэм нөхөд, хөх тэнгэрийн зарлигаар заяасан төрсөн нутаг ус, элгэн садан гээд хамаг бүгдээ орхин алс хэтийн нутаг, аян дайны талбарт алтан амь гарсны гэрч болон бичигдсэний хувьд түүхэн ач холбогдолтойгоос гадна уран сайхны ур хийцийн хувьд гойд үнэ цэнэтэй юм. Учир нь бие барж тэнгэрийн орноо заларсан их хааныхаа сүр сүлд, сүнс онгоныг хөх тэнгэрийн мандалд эрх дураараа халин дүүлэх шувууны жигүүр лүгээ адил дэвэн одов хэмээн сэтгэж дүрсэлсэн нь гойд уран хийсвэрлэл, онцын уран дүрслэл болжээ. Энэ дүрслэлээ улам бататгахын үүднээс эгэл энгийн ахуй амьдрал руу шилжилт хийж, сүлд сүнс нь “шувууны жигүүр болон” халин дүүлж одсон “хас эрдэнэ мэт” бие цогц нь “хангинах тэрэгний тээш болов” хэмээн өгүүлжээ. Эзний сүнс онгод болон мөнхөрч, бие нь ачаа тээш болов гэсэн санаа энд тодорхой. Уг санаагаа дараа дараагийн бадгууддаа давтаж үе үг, холбоо хоршоо, мөр бадаг бүхэнд нь харуусал гашуудлын утгаа нэвт шингээж чадсаны хувьдаа энэ шүлэг онцгой уран сайхантай болжээ. Энэ уран дүрслэлт сэтгэлгээгээ ертөнцийн буй хийгээд үгүйн цөм язгуур мөн чанар болсон хослолд тулгуурлан хос уянгаар бадаглаж, эхний мөрөнд нь оюун сэтгэлгээнийх нь, дараагийн мөрөнд нь бие цогцынх нь тухай өгүүлэхдээ уран сайхан хэлэгдэж, яруу тунгалаг сонсогдож байх зарчмын үүднээс ертөнцийн хэм тэгшийн загвараар хос мөрийн үе, айзам хэмнэлийг тааруулаж, монгол хэлний хамгийн эгшиглэнтэй сонсголонт гийгүүлэгчүүдийн утга үүрэгт дулдуйдан өгүүлснээр шүлгээ толгой, сүүлийн холболтод захируулан хайрцагласан нь шүлэгчийн авьяас билгийг харуулаад зогсохгүй монгол шүлгийн бүтэц тогтолцоо хийгээд шүлэглэх бололцоо нөөцийн ундаргыг харуулж байна.

Монгол шүлгийн өвөрмөц нэгэн хэсэг болох сургаалын яруу найраг “Оюун түлхүүр нэрт шастир”-т:

Арслан мэт ноёдыг

Барс мэт түшмэд дагах

Барс мэт ноёдыг

Ирвэс мэт түшмэд дагах

Ирвэс мэт ноёдыг

¹³ *Qad-un ündüsün quriyanguui altan tobči*. Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Шаравын Чоймаа. Уб., 2002. 58 дугаар тал

Чоно мэт түшмэд дагах

Чоно мэт ноёдыг

*Үнэг мэт түшмэд дагах*¹⁴ ... гэсэн шүлэгт утгын холбоосоос үүдээд толгой холбоогүй ч сүүлийг уран сайхны сөөлжүүлэх аргаар бүхэл үгээр нарийн чанд холбосон нь тухайн шүлгийн агуулгыг гүнзгийрүүлэн, хэлбэрийг төгөлдөржүүлж, шадуудын хоорон дахь айзам хэмжээний зохирлыг зөв тааруулсан байна.

Энэ бүхэн бол аман болоод эртний шүлэг найрагт сүүл холбоц /айзам хэмнэл тааруулах, нэг шатаас нөгөө шат ундрах ундраг гэх мэт/ чухал үүрэгтэй байсныг харуулж байна. Тэгвэл орчин үеийн яруу найргаас цөөн жишээ татаж үзье. XX зууны эхэн үеийн монгол яруу найргийн нэртэй төлөөлөгч Д. Нацагдорж “Миний нутаг” шүлэгтээ:

Хэнтий, Хангай, Саяаны өндөр сайхан нуруунууд

Хойт зүгийн чимэг болсон ой хөвчийн уулууд

Мэнэн, Шарга, Номины өргөн их говиуд

Өмнө зүгийн манлай болсон элсэн манхан далайнууд

Энэ бол миний төрсөн нутаг

*Монголын сайхан орон*¹⁵ ... хэмээн өгүүлсэн байна.

Д. Нацагдорж “Миний нутаг”-аа бичсэн тухай түүний үе тэнгийн найз Т. Нацагдорж дурсахдаа. “Тэрбээр:

Ай галзуу чонон хөлөгтөнгүүд

Гал могой ташууртангууд

Хүний махан хүнстэнгүүд

Хүрэл чулуун зүрхтэнгүүд ... гэж бичээд, “шүлгийн зохион байгуулалт тун сайн.

Ритм, такт маш жигд. Үгийн үе хуваарь адилхан байна. Хуучнаас шинийг олж авах хэрэгтэй байдаг. Шүлэг бичих нэг л сүрхий техник байна” гэж өгүүлэн хожим нь “бөөгийн шүлгийн ритмийг судалж амжсан” гээд “Миний нутаг” шүлгээ уншсан”¹⁶ тухай дурсамж хийгээд уг шүлгийг судалсан судлаачдын бүтээлээс¹⁷ харахад аман яруу найраг дахь холбоцуудын тогтолцоо, түүнээс үүдэлтэй айзам хэмнэл, утга агуулгын хослолыг урлах аргаас уламжлалтай нь харагдана. Уг шүлгийн төгсгөлийг олон тооны “-ууд”² нөхцөлөөр ижилсүүлэн холбож мөр бүрийн айзам хэмнэлийг жигдлэн улмаар яруу сонсголонтой болгосон байна. Бидний үзэж байгаагаар бол уг шүлгийн нэг онцлог нь шүлгийн төгсгөлийг зориуд олон тооны “-ууд, -үүд” гэсэн нөхцөлөөр жигдлэн холбосон нь өргөлтөд жигд хэмнэлийг үүсгэж шүлгийн толгой холбоцын өргөлттэй нэгэн түвшинд адилтгаж чадсанд оршиж байх шиг. Учир нь монгол хэлний өргөлт онолын хувьд үгийн тэргүүн үедээ байхыг үгүйсгэхгүй ч урт, хос эгшиг, сонсголонт гийгүүлэгчүүдийн өмнөх юмуу хойнох эгшиг заавал өргөлттэй нь харагдаж байгаа юм. Д. Нацагдорж монгол хэлний энэ шинжийг нарийн анхаарч шүлэгт бодит байдлаар илэрхийлэн харуулж, улмаар шүлгийнхээ шад хоорондын айзам хэмнэл, аялгуу холбоцыг монгол хэлний өргөлтийн хуулиар жигдэлж чадсан байна. Тийм ч учраас

¹⁴ Оюун түлхүүр нэрт шастир. Эхийг харьцуулан, кирилл үсэгт хөрвүүлж, тайлбар хийсэн Шаравын Чоймаа. Уб., 2006. 20-21 дүгээр тал

¹⁵ Нацагдорж Д. Бүрэн түүвэр. Удиртгал бичиж редакторлосон Д. Цэдэв. Уб., 1996. 93 дугаар тал

¹⁶ Нацагдорж Т. Зохиолчийн дурсгалд. Туяа. 1957. №4

¹⁷ Содном Б. Дашдоржийн Нацагдоржийн намтар зохиол. Уб., 1966. 266 дугаар тал, Герасимович Л. К. Литература Монгольской Народной Республики. (1921-1964 годов) Л., 1965. срт-68, Лувсанвандан С. Д. Нацагдоржийн шүлгийн холбоцын зарим асуудал. Утга зохиол, урлаг. 1975. №45

түүний шүлгийн холбоцыг нарийвчлан судалсан судлаач С. Лувсанвандан “Д. Нацагдоржийн шүлгийн сүүл холбоц бол тохиолдлын зүйл биш тогтолцоотой урлаг байна. “Миний нутаг” шүлэгт бадаг бүрийн төгсгөлийг холбохын сацуу “миний төрсөн нутаг, монголын сайхан орон” давталтыг бадгийн хайрцаг шүлгийн бүтэц, шүлэглэх айзам хэмжээний цогцос болгожээ”¹⁸ хэмээн бичсэн байна.

Яруу найрагч Б. Явуухулан “Туулын урсгал шөнөдөө сайхан” гэсэн шүлэгтээ:

Туулын урсгал шөнөдөө сайхан сан

Торгон долгио хаялан мяралздаг сан

Хоёр ангир дандаа л хөвдөг сөн

Холын анир авангаа л дуугардаг сан¹⁹ ... хэмээн “-сан” нөхцөлөөр мөр бүрийн төгсгөлийг жигдлэн нарийн чанд холбосноор мөр хооронд жигд хэмнэл үүсэж, эхний мөрөөс дараагийн мөр, хоёр дахь мөрөөс гурав дахь мөр, гурав дахь мөрөөс дөрөв дэх мөр, улмаар энэ бадгаас дараагийн бадаг урган гарсан нарийн зүй тогтолыг үүсгэсэн байна. Энэ нь шүлгийн сүүл холбоц мөр хоорондын жигд хэмнэлийг үүсгэхэд чухал үүрэгтэйгээс гадна дараа дараагийн мөр бадгуудын эх ундарга болдогыг харуулна. Хэлэх, сэтгэх үйлтэй уялдаатайгаар авиа үсгийн ижилсэн зохицох тогтолцоонд үндэслэгдэж шүлгийн холбоцууд үүсдэг байна. Иймд монгол хэлний авиа үсэг хэлэгдэх байдал, утгаараа нэгээс нөгөө нь урган гарсан тодорхой нарийн эрэмбийн дагуу оршдог болох нь харагдана. Цаг хугацааны шүүлтүүр давж, үндэстнийхээ сэтгэлгээний түүхэн зүй тогтолыг хадгалсан төгс утгат тогтолцоот хэмжээг үүсгэсний удвасаар хүний сэтгэлийг хөдөлгөж, ухааныг нэрэх нь шүлэг найргийн үндсэн шинж.

Орчин үеийн шүлэгт ч аман ба бичгийн шүлгийн нэгэн адил сүүл холбоц чухал үүрэгтэй байгааг харж болохоор байна. С. Буяннэмэх шүлгийн сүүл холбоцын тухай “Ер нь холбоо найруулгыг зохиохдоо гагцхүү толгой тохируулахаар дуусгах биш хормой сүүл тохируулах нь хамгийн чухал чадвар болох ба уул холбоо найруулгын уран сайхны онц чимэгүүдийн гоё сайхан зүйл ба үгийн эв эгшиг, аялгууны тохиромжтой сайхан болох нь ийм зүйлүүд дээрээс нэн сайн болно.”²⁰ хэмээн онцлон тэмдэглэжээ. Тиймээс монгол шүлгийг судалсан судлаач Д. Цэнд “Толгой холболтын зэрэгцээгээр бадаглах шүлгийн мөрийн сүүл хормой холбох нь монгол шүлэгт өргөн дэлгэрсэн зүйл бөгөөд манай шүлгийн байгууламжинд орчин үед улам ч дэлгэрлийг олж байна.”²¹ хэмээн бичсэн байна. Мөн буриад шүлгийг судалсан судлаач Г. Туденов “шүлгийн мөрийн сүүлийг ижилсүүлэн холбох нь айзамын нэгж өлмийг үүсгэж байгааг харуулж байгаа хэрэг”²² хэмээн сонирхолтой дүгнэт хийжээ.

Шүлгийн холбоц гэдэг эцсийн дүндээ шүлгийн уран сайхан, үнэ цэнийн асуудал тул монголын эртний аман яруу найргаас эхлүүлээд эдүүгээ цаг хүртлэх чанартай сайн гэж тооцож үзсэн /уран зохиолын үнэ цэнийн тухай онолын энгийн шалгууруудыг давсан/ мянга орчим шүлгийн холбоцонд статистик судалгаа хийж үзэхэд 90 гаруй хувь нь ямар нэгэн хэлбэрээр толгой холбоцтой, 40 орчим хувь нь дунд холбоцтой, 60 орчим хувь нь сүүл холбоцтой байгаа нь харагдаж байна. /Монгол шүлгийн тоон судалгааны талаар “Монгол шүлгийн статистик судалгаа” гэсэн тусгай өгүүлэл бичиж байгаа тул

¹⁸ Лувсанвандан С. Д. *Нацагдоржийн шүлгийн холбоцын зарим асуудал*. Утга зохиол, урлаг. 1975. №45

¹⁹ Явуухулан Б. *Түүвэр зохиол*. Эмхтгэсэн Ж. Адъяа, Я. Баатар. Уб., 1985. 185 дугаар тал

²⁰ Буяннэмэх С. *Утга зохиолын үүд*. (Гар бичмэл эх) Уб., 1936. 113 дугаар тал

²¹ Цэнд Д. *Монгол шүлгийн тогтолцооны асуудал*. “Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд” Уб., 1979. 166-167 дугаар тал

²² Туденов Г. *Бурятской стихосложение*. Улан-Удэ., 1958. стр-142

энэ удаа дэлгэрэнгүй өгүүлсэнгүй./ Энэ ерөнхий дүгнэлтээс авч үзвэл толгой холбоц шиг сүүлийг түгээмэлээр холбоогүй байгаа нь нэгд, шүлгийн утга санааг бүрэн гаргахад боломжийг ямар нэг талаар хаадаг талтай холбоотой, хоёрт, монгол хүний сэтгэлгээгээр аливаа зүйлийн эхлэлийг онцгой чухалчилж үздэг учир шүлгийн толгой холбоцыг заавал хийдэг бол аливаа зүйлийн төгсгөлийг тэр бүр хурдан шуурхай хийгээд байхыг цээрлэдэг сэтгэлгээтэй цаанаа холбоотой, гуравт, монгол хэлний өргөлтийн зүй тогтолтой хамааралтай бололтой. Дөрөвт *“Гагцхүү ард түмний амнаас ам, үгнээс үг дамжин билүүдэгдсэн бүтээл шиг сайн боловсруулах тэсвэр авьяас бие даасан зохиолчдод дутдагаас амарчлан толгой холбоод сүүлийг нь хайхрамжгүй орхидогоос монгол шүлэг тодорхой зохиолчдын амаар орохоороо дутуу төрдөг болсоор удсаны балгаар сүүл холбож болохгүй юм шиг мэдэн будилахад хүртэл доройшилжээ. Сүүл холбох бололцоо монгол хэлний үгсийн санд байтугай аман зохиолын олон төрөл зүйлд маш баялаг хувилбараар байсаар ажээ.”*²³ Гэхдээ энэ бүхэн монгол шүлгийн сүүл холбоц толгой, дунд холбоцын үргэлжлэл болж, шүлгийн хэмжээ хэмнэл, бадаглалыг үүсгэхэд чухал үүрэгтэй бие даасан тогтолцоот үзэгдэл болохыг үгүйсгэж үл чадна.

Монгол шүлгийн сүүл холбоцын тухай дээр өгүүлсэн зүйлүүдийг нэгтгэн доорх дүгнэлтийг хийж байна.

Монгол шүлгийн сүүлийг тогтвортой холбох ёс эртний аман зохиолын олон төрлүүд төдийгүй эрт эдүүгээгийн бичгийн яруу найрагт ч тогтвортой хадгалагдан ирсэн байна. Энэ нь сүүл холбоц шүлгийн айзам хэмнэлийг зангидан, утга агуулгыг яруу тодорхой илэрхийлэх үүднээс урган гардаг тогтвортой зүйл болохыг харуулж байна. Гэхдээ монгол шүлгийн толгой холбоц шиг нэн түгээмэл үзэгдэл биш ч дунд холбоцыг бодвол илүү нарийн тогтвортой үзэгдэл гэж болно. Монгол шүлэгт сүүл холбоц утгат өгүүлбэрт шадын /мөр/ хувьд задгай үеийг илэрхийлэн хадгалах тул шадын айзам хэмнэлийг тааруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Үүгээрээ толгой холбоц болоод дунд холбоцоос онцлог төдийгүй давуу үүрэгтэй юм.

Монгол шүлэгт толгой холбоц голлох үүрэгтэй ч сүүл болоод дунд холбоцоо захиран ижил холбоц үүсгэдэггүй байна. Өөрөөр хэлбэл толгой холбоц зэрэгцэх холбоцтой байхад сүүл холбоц нь салаавчилсан, хашсан зэрэг холбоцтой байж болдог ажээ. Энэ нь сүүл холбоц толгой холбоцоос хараат бус бие даасан үүрэг зорилготой болохыг харуулж байна. Монгол шүлэгт толгой холбоц тэргүүлэх үүрэгтэй ч дунд болоод сүүл холбоц бие даасан хэлбэрт байгаа нь монгол шүлгийн холбоцууд харьцангуй чөлөөтэй тус бүрдээ бие даасан үзэгдэл болох нь ойлгогдож байна. Монгол шүлэгт толгой холбогдоогүй үед сүүл холбогдсон байвал тэрхүү холбоц илүү тогтвортой байж, шүлгийн айзам хэмнэл, утга агуулгын цөмийг зангидаж, бие даасан тодорхой бүтэц тогтолцоог үүсгэдэг онцлог ажиглагдаж байна.

Монгол шүлгийн сүүл холбоц толгой холбоц шигээ нэн түгээмэл биш ч харьцангуй тогтвортой байдаг байна. Монгол шүлгийн толгой холбоцын ерөнхий зүй тогтол нэг авиа үсгээр гэхээсээ илүү бүхэл үеэр холбогдон зангилагдахыг²⁴ чухалчилдаг бол сүүл холбоц нь утгат хэсэг хийгээд айзам хэмнэлт нөхцөл, залгаврын арга, баймж үгэнд тулгуурласан байх нь түгээмэл аж.

²³ Түдэв Л. *Шүлэглэсэн туульс*. Бүтээлийн чуулган. VI боть. Уб., 2002. 332-333 дугаар тал

²⁴ Галбаяр Г. Д. *Нацагдорж, Б. Явуухулан нарын шүлгийн толгой холбоцыг харуулах нь*. МУИС-ийн МХСС-ийн МОНГОЛ СУДЛАЛ эрдэм шинжилгээний бичиг. Боть XXXII(340). Уб., 2010., 122-130 дугаар тал -

Шүлгийн сүүл холбоц толгой, дунд холбоцын нэгэн адал шүлгийн сонголт шинж чанар, зохиомжийн байгууламжинд чухал үүрэг гүйцэтгэдгийн хувьд жигд хэмнэлд үндэслэгдсэн байдаг. Өөрөөр хэлбэл монгол шүлэг сүүл холбоцтой байгаа нь мөр хоорондоо жигд хэмнэлтэй байгааг, цаашлаад холбоцтой мөрүүд тэнцүү үе, үгээс бүтдэг нь харагдаж байна. Тиймд монгол шүлгийн нэг гол шинж бол шүлгийн шадууд тэнцүү үе, үгтэй байх, улмаар нарийн чанд холбоцтой байхад оршино.

SUMMARY

Now it is important to explore life of the Mongols and the historical events in complex with intellectual culture and heritage on the basis of their relationships and modern sciences. Some of these issues are subjects for extensive research, especially the nature and structure of Mongolian poetry, which evolved reflecting style and form of thinking of the Mongolian people. Since the study of Mongolian poems is a versatile and broad issue, which includes historical system, structure, inner essence, this time we have explored in depth only a few features of rhyme of Mongolian poems and made the following conclusions.

The tradition of rhyme in Mongolian poems is observed not only in many types of ancient oral literature, but also preserved in the written literature from the ancient times. This shows that the rhyme comes from a need to unite not only the measure and cadence of lyrics, but also emphatically express the content. While this is not a common phenomenon like anaphora, but it has more regular occurrence and more compound compared with middle rhymes. Since the rhymes evolves open syllable for poem verses in semantic sentences, it performs a vital role to match the rhythmic of verses. This is the most important feature of rhyme that distinguish it from anaphora and middle rhyme.

Although the anaphora has the most vital role in Mongolian poems, it also controls rhymes and middle rhymes and subsequently do not allow to create the similar rhymes. In other words, if the anaphora has the synchronized rhyme while the rhyme has rotating rhymes. This shows that rhyme is not dependent from anaphora. Although anaphora has the leading role for Mongolian poems, rhymes and middle rhymes have more independent property, so the last ones are relatively free and independent phenomena. If there is no anaphora in Mongolian poems, but there is a rhyme this became more stable, integrates all rhythm and content of the lyrics and creates independent structure.

Rhymes in Mongolian poems are not common like anaphora, but they are more stable. Also it is clear to see that rhymes are connected by repeating predicates in clause sentences formed by conditionals.

Rhymes like anaphor and middle rhymes play the equal role in the melody and expressiveness of poem. In other words, rhymes in Mongolian lyrics show that the poem has the equal rhythms between the lines as well as lines with rhymes consist of equal syllables and words. Therefore the main property of Mongolian poems is the lines in a verse have equal syllables and words and subsequently to have extremely chastity rhymes.

НОМ ЗҮЙ

- Байгалсайхан С. *Уран зохиол шинжлэлийн удиртгал*. Уб., 1995
- Буяннэмэх С. *Утга зохиолын үүд*. (Гар бичмэл эх) 1936
- Гаадамба Ш. *Утга зохиолын онолын товч*. Уб., 1957
- Гаадамба Ш., Цэрэнсодном Д. *Монгол аман зохиолын дээж бичиг*. Уб., 1978
- Галбаатар Д. *Уран зохиолын онолын ойлголт, нэр томъёоны тайлбар толь*. Токио., 2002
- Галбаяр Г. *Уран зохиол шинжлэлийн лекц*. Уб., 2002
- Герасимович Л. К. *Литература Монгольской Народной Республики*. (1921-1964 годов) Л., 1965.
- Герасимович Л. К. *Монгольское стихосложение*. Л., 1975
- Гүлранса, Данзанванжил, Хишигбат Түүвэр. *Хөх хот.*, 1959
- Дамдинсүрэн Ц. *Гадаад хэлнээс шүлэг орчуулах тухай өгүүлэл*. “Шинэ толь” сэтгүүл. Уб., 1938. №2 (14)
- Дамдинсүрэн Ц. *Олег цэцэний орчуулгын тайлбар*. Монгол хэл бичгийн тухай эмхэтгэл. Уб., 1957
- Дулам С., Хасбаатар Ц. *Утга зохиолын үүд*. Уб., 1980
- Жамба Д. *Монгол шүлгийн хэлний тухай өгүүлэл*. Монгол түүх хэл бичиг сэтгүүл. Уб., 1958. №3
- Жамбалсүрэн Н. *Монгол шүлэг*. Утга зохиол сонин. №8 1956
- Жирмунский В. *Теория стиха*. Л., 1975
- Инжаннаши В. *Хөх судар*. Тэргүүн дэвтэр. Хөх хот., 1959
- Kara G. *Old Mongolian verses without alliteration*. “Ananies USBRE” section linguistic. Budapest., 1972
- Квятковский А. *Поэтический словарь*. М., 1983
- Лауфер Б. *Очерк монгольской литературы*. Л., 1927
- Лувсанвандан С. Д. *Нацагдоржийн шүлгийн холбоцын зарим асуудал*. Утга зохиол, урлаг. 1975. №45
- Монголын нууц товчоо*. Галиглаж хэвлүүлсэн Т. Дашцэдэн. Уб., 1985
- Нацагдорж Дашдоржийн *Бүрэн зохиол*. Удиртгал бичиж редакторлосон Д. Цэдэв. Уб., 1996
- Нацагдорж Т. *Зохиолчийн дурсгалд*. Туяа. 1957. №4
- Отгонсүрэн Д. Д. *Нацагдоржийн зохиолын хэл найруулга уран сайхны онцлог*. Уб., 1984
- Оюун түлхүүр нэрт шастир*. Эхийг харьцуулан, кирилл үсэгт хөрвүүлж, тайлбар хийсэн Шаравын Чоймаа. Уб., 2006
- Позднеев А. М. *Образцы народной литературы монгольских племен*. Вып 1. Спб., 1880
- Поуха П. “Монголын нууц товчоо”-ны зарим нэгэн шинэ судалгаа. Монгол судлал. Уб., 1968
- Ринчен Б. *Монгол шүлгийн учир*. “Хэл зохиол” цуврал бичиг. Уб., 1969
- Руднеев А. *Образцы монгольской народной словесности*. СПб., 1880
- Содном Б. Д. *Нацагдоржийн уран зохиолын тухай*. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. IV дэвтэр. Уб., 1962
- Содном Б. *Дашдоржийн Нацагдоржийн намтар зохиол*. Уб., 1966.

Содном Балданы *Монгол шүлгийн арга маяг*. Зохиол судлал. Уб., 2008-2009

Туденов Г. *Бурятской стихосложение*. Улан-Удэ., 1958

Түдэв Лодонгийн *Шүлэглэсэн туульс*. Бүтээлийн чуулган VI. Уб., 2002
Qad-un iindüsin quriyangui altan tobči. Галиглаж, үгийн хэлхээг үйлдэн, эх бичгийн судалгаа хийсэн Шаравын Чоймаа. Уб., 2002.

Хамгашалов А. *Опыт исследования бурят-монгольского стихосложения*. Улан-Удэ., 1940

Kesigtoytaqu Š. *Mongyol-un erten-ü udq-a jokiyal-un sin-e sudulul*. Öbür mongyol-un arad-un keblel-ün qoriy-a., 1999

Хүрэлбаатар Л. *Сонгодог уламжлал, монгол яруу найраг*. Уб., 1989

Цэдэв Д. *Монгол яруу найргийн уламжлал шинэчлэл*. Уб., 1974

Цэнд Д. *Монголын орчин үеийн уянгын яруу найраг*. Уб., 1972

Цэнд Д. *Монгол шүлгийн тогтолцооны асуудалд*. “Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд” Уб., 1979

Цэрэнсодном Д. *Монгол шүлгийн онол түүхийн зарим асуудал*. Уб., 1977

Чимид Ч. *Монгол шүлгийн тогтолцоо*. “Үгийн ил шид” эмхэтгэл. Уб., 1968

Erten-ü qad-un iindüsüleksen törü yosun-u jokiyal-i tobčilan quriyaysan altan tobči kemekü orusibai. Orusil bičigsen Ša. Bira., Ulaanbaatur., 1990

Явуухулан Бэгзийн *Түүвэр зохиол*. Эмхтгэсэн Ж. Адъяа, Я. Баатар. Уб., 1985